

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦОО

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/-ийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу шалгах үзвэл:

1.Иргэнд үүсэх зардлыг цаг хугацааны болон шууд бий болох мөнгөн зардал гэсэн үзүүлэлтээр нэг жилд бий болох зардлыг тооцож гаргадаг бөгөөд хуулийн төсөлд иргэнд ямар нэг үүрэг болгосон заалт байхгүй тул түүнд зарцуулах хугацаа, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал үүсэхгүй болно.

2.Хуулийн этгээдэд нэг жилд бий болох хүний нөөцийн болон мөнгөн зардлыг тооцдог бөгөөд уг аргачлалын дагуу дараах зардлын тооцоолол гарч байна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 2-т “29.4.Орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга нь хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсч байгаа талаарх гомдлыг үндэслэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгүүлэх тухай хүсэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.” гэж тусгасан байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 болон 9 дүгээр зүйлд зааснаар зардлыг төсөл хэрэгжүүлэгч тал буюу тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцана. Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2013 оны А/407 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх журам”-н 3.1.1-т “Төсөл хэрэгжүүлэгч нь анхан шатны үнэлгээ, дэлгэрэнгүй үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.”, мөн журмын 3.2.3-т “Үнэлгээний зардлыг төсөл хэрэгжүүлэгч бүрэн хариуцна.” гэж тус тус тодорхойлсон байна.

Иймд энэхүү зохицуулалтын дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн явуулж буй үйл ажиллагаатай холбоотойгоор эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдээс гомдол гаргасан тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэр гаргасан тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдээс байгаль орчинд нөлөөлөх байдлын нэг үнэлгээ хийлгэхэд шаардлагатай зардлыг дараах байдлаар тооцох боломжтой байна.

№	Зардлын ангилал	Үйл ажиллагааны задаргаа	Тоо/Нэгж	Нэгжийн үнэ (төг)	Нийт зардал (төг)
1	Мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгэх	Байгаль орчны үнэлгээний тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр БОНБУ хийлгэх	1 үнэлгээ	25,000,000	25,000,000
2	Талбайн судалгаа, газар дээрх хэмжилт	Дэлгэрэнгүй хэмжилт, хөрс, ус, агаарын дээж авч шинжилгээ хийх	1 төсөл	5,000,000	5,000,000
3	Шинжилгээний лабораторийн зардал	Хөрс, ус, агаар, дуу чимээний хүлээн зөвшөөрөгдсөн лабораторийн шинжилгээ	10 сорьц	300,000	3,000,000
4	Орон нутгийн иргэдтэй зөвлөлдөх уулзалт	Орон нутгийн олон нийтийн оролцоог хангах зөвлөлдөх уулзалтын зохион байгуулалт (түрээс, хэвлэл, унаа)	1 удаа	1,500,000	1,500,000
5	Тээвэр, зочид буудал, томилолт	Үнэлгээний багийн аяллын зардал (3 хүн, 3 хоног, орон нутгийн чиглэлд)	3 хүн * 3 хоног	250,000	2,250,000
6	Нотариат, баталгаажуулалт, тайлан хэвлэлт	БОНБУ тайланг хуулийн дагуу хэвлэх, баталгаажуулах	1 тайлан	500,000	500,000
7	Нөөц зардал (10%)	Үнийн хэлбэлзэл, нэмэлт зөвлөх үйлчилгээ	—	—	3,725,000
8	Нийт			41,975,000 төгрөг	

3.Төрийн байгууллагад хүний нөөц шинээр болох, шинэ бүтэц бий болохтой холбоотой зардлыг нэг жилээр тооцож гаргах бөгөөд хуулийн төслийн зохицуулалтаас харахад ийм төрлийн зардал бий болохооргүй байна.